

ЛУВСАН ХУУРЧИЙН ХУУРДАН ХЭЛСЭН “БОДЬ МЭРГЭН ХААН”-Ы  
ҮЛГЭР ХИЙГЭЭД “САХИУЛСАН ӨРГӨМЖИЛСӨН ҮЛГЭР”-ИЙН  
ӨГҮҮЛЭМЖИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖЛЭЛ<sup>1</sup>

Цогт

**Товч агуулга:** Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн өгүүлэмж хийгээд “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн өгүүлэмжийн харьцууллаас доорх дүгнэлтийг олжээ. Нэгд, Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэр нь “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ээс ирсэн байна. Хоёрт, Лувсан хуурч “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийг хуурдахдаа “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн өгүүлэмжийг өөрчлөхийг нь өөрчилж, солихыг нь сольж, заримыг нь бас шинээр зохион хуурджээ. Гуравт, Лувсан хуурч үлгэрийнхээ өгүүлэмжийг монгол сонсогчдын дур сонирхолд нийцүүлэн бөө мөргөл, бурхан шашин ба монгол зан заншилд зохицуулан хуурдан хэлсэн байна.

**Түлхүүр үг:** *Лувсан хуурч, Бодь мэргэн хаан, Сахиулсан өргөмжилсөн үлгэр, өгүүлэмж*

Өлзийн Лувсан хуурч (1885-1943)<sup>2</sup>-ийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан” нь баатрын тууль уу? Хуурын үлгэр үү? гэдэг асуултад эрдэмтэд одоо болтол адил бусын үзэлтэй байсаар. Жишээлбэл: “Бодь мэргэн хаан” гэдэг үлгэрийг шинжлэх ухааны галигаар бичиж авсан Бямбын Ринчен ба Зөвлөлт Холбоот Улсын хөгжим судлаач эрдэмтэн Сергей Александрович Кондратьев нар өөрийн бүтээлдээ “Бодь мэргэн хаан”-ыг бэнсэн үлгэр буюу хуурын үлгэр хэмээн үзсэн байна. Гэвч сүүлийн үед Монгол улсын зарим эрдэмтэд “Бодь мэргэн хаан”-ыг том тууль гэж үзэх болсон байна (МТТТ, 2013:117). Бээжингийн Их Сургуулийн Дулаан профессор энэхүү маргаантай асуудалд зөв хариулт өгөхийн төлөө “Бодь мэргэн хаан”-ы үндсэн агуулгын дотор баатрын туулийн уламжлалт агуулга гол болох уу? Хуурын үлгэрийн агуулга гол болох уу? гэдэгт задлалт хийгээд “Бодь мэргэн хаан” хэмээх үлгэрт хуурын үлгэр буюу бэнсэн үлгэрийн өгүүлэмж үлэмжхэн байх бөгөөд үлгэрийн үйл явдлын хөгжилтөд зангилааны үүрэг гүйцэтгэж байгаа өгүүлэмж нь яг бэнсэн үлгэр буюу хуурын үлгэрийн өгүүлэмж болно” (2017:42) хэмээн дүгнэсний хамт “дээр өгүүлсэн

<sup>1</sup> Тус өгүүлэл бол БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний анхаарагдаагүй буюу уламжлал тасарсан шинжилгээний салаагийн тусгай төсөл-Төвийн Үндэстний Их Сургуулийн Дунддын үндэстний уламжлалт соёлын солилцооны судлалын багийн төсөл болох “Монгол үндэстний аман уламжлал хийгээд монгол, хятад соёлын уусалцал” (20VJXT008)-ийн шатач чанартай бүтээл болно.

<sup>2</sup> Лувсан хуурчийн намтар түүх ба түүний хэлсэн үлгэр туулийн талаар Монгол улсын Цэндийн Дамдинсүрэн, Бямбын Ринчен зэрэг нэрт эрдэмтэн тусгай зохиол бичиж танилцуулснаас гадна сүүлийн жилүүдэд Өвөр Монголын эрдэмтэд ч тусгай өгүүлэл зохиол бичиж судалцгааж байна. Ринчиндорж: *Монгол улсын алдарт хуурч Өлзийн Лувсангийн товч намтар*. Анхдугаар удаагийн хуурын үлгэрийн форумын өгүүлийн түүвэр. Өвөр монголын Үндэстний Их Сургууль, 2013 оны 10 сар, дотоод материал. Нарангэрэл: *Лувсан хуурчид холбогдох түүхийн баримт материалаар сэдэвлэх нь-Хуурын үлгэрийн өвийг цуглуулах ба судлах асуудалд тавих санал*. Өвөр монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2013 оны 3 дугаар хугацаа. Дулаан: *Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн ‘Бодь мэргэн хаан’ хэмээх үлгэрийн тухай судлал*. Уламжлал ба харьцуулал-Утга зохиол судлалын хэлхээгүй сувд (дээд дэвтэр). 2017. Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо. х.29-60.

хэдэн талын үндсэн асуудлуудын суурин дээр ‘Бодь мэргэн хаан’-ы үлгэрийг нэн олон бэнсэн үлгэр, тэрчлэн ‘Сахиулсан өргөмжилсөн үлгэр’ зэрэг Хятадын шидэт романуудтай харьцуулан судалж нарийсаг шинжлэх ажил манай өмнө тавигдаж байна” (2017:58) хэмээн нандин саналаа дэвшүүлжээ. Бидний үзэхээр Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийг Хятадын шидэт роман “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-тэй харьцуулан шинжлэх нь тус маргаантай асуудлыг шийдвэрлэхэд чухал лавлалтын үнэ өртөгтэй мөртөө Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн эх эрэлтийг судлахад тун чухал үнэ цэнтэй ажиллагаа болно. Доор бид Өлзийн Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн гол болох хэдэн өгүүлэмжийг “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-гийн өгүүлэмжтэй харьцуулан судалж үзье.

### Нэг. Хувилж улирах өгүүлэмж

Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт тэнгэрийн охин Цагаангалуугаар хаан эзний их хатныг шулам хатны хорлолоос аврахын төлөө биеэ эрвээхэй болгон хувилгасан тухай: “охин Цагаангалуу, дунд хатны ордонд орох гэсэн, орох газар үгүй, үүгээр түүгээр нисэж яваад, магниг (торгоны өнгө) өнгөтэй эрвээхэй болоод, хоёрдугаар хатны үүдээр орох гэсэн орж болсонгүй. Цонхны цаасан дээгүүр нь яваад байжээ. Нэг жаахан нүхээр нь орж, буурал хатны аман дээр очоод суучихжээ” (2016: 27)<sup>3</sup> гэж өгүүлсэн байна. Энд тэнгэрийн охин Цагаангалуу Бодь мэргэн хааны их хатныг аврах хэмээн үүд хаалгаа няц дарж чанга сэргийлэлттэй байсан шулам хатны ордонд орохын төлөө өөрийн биеэ эрвээхэй болгон жижгэрүүлж, шулам хатан ба Хожгорхүүхэнийг мэхлэн, их хатныг аюулаас аварсан учрыг тоочжээ.

Хуурчаар “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хоёрдугаар хатны аягач Хожгорхүүхэнийг туйлын муухай төрснөөр дүрсэлсэн юм. Түүнд хуурчаар Хожгорын амаар “Өндрөөшөө тохой биетэй, өргөнөөрөө гурван чи (尺 chǐ) таван цунь (寸 cùn) биетэй. Тал толгой минь Хожгор, тал (өрөөсөн) нүд минь сохор, тал (өрөөсөн) хөл минь доголон, тал (өрөөсөн) гар минь тахир билээ!” (P15) хэмээн дүрсэлсэн байна. Гэтэл Хожгорхүүхэн бол улирч хувилах чадвартай, тэр хааны хоёр тайзын (太子 tài zǐ) хайрыг олохын төлөө муухай зүс царайгаа “гоо үзэсгэлэнтэй зүсийг хувилаад” (P53) хоёр бага тайзтай хамтаар далайн усанд алтан түмпэнгээр (銅盆 tóng pén) наадсан байна. Энэ бол бас нэг зүйлийн улиран хувилах өгүүлэмж болох юм. Хожгорхүүхэн хэдийгээр бусад зүйлийн амьтанд улиран хувилсангүй боловч өөрийн муу муухай өнгө зүсээ гоё зүст хувилж хүнийг мэхлэн өөрийн зорилгодоо хүрсэн байна.

Хятадын шидэт роман “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т жанжин баатар, амьтан, бодист улиран хувилах өгүүлэмж тун олон гардаг. Жишээлбэл: “Юй дин жэнь рэнь (玉鼎真人 yù dǐng zhēn rén)-ээр Яан жянь (杨戩 yáng jiǎn)-ийг дуудан өгүүлрүүн: “чи энэ үдэш тэнд эчиж (очиж) Хуан лун жэнь рэнь (黄龙真人 huáng long zhēn rén)-ийг тавьж ирүүлтүгэй” хэмээсэнд Яан жянь зарлигийг хүлээн авав. Нэгэн жингийн цаг дор Яан жянь ялаа хувилж нисэж эчээд (очоод) Хуан лун жэнь рэний чихэн дэргэд хүрч сэмхэн өгүүлрүүн: “сургаалын авга (нэг багшийн шавь), шавь Яан жянь зарлигийг хүлээж чамайг тавихаар ирэв. Хэрхвээс хялбар гарч чадмуй” хэмээхэд Хуан лун жэнь рэнь өгүүлрүүн: “чи миний зулай дээрх бичгийг авбаас би өөрөө салмуй”” (1984:390-391) гэж өгүүлэн тоочив. Энд Яан жяний ялаа болон хувилж, дайсанд баригдсан Хуан лун жэнь рэнийг авран гаргасан учрыг өгүүлжээ. Тус үлгэрт Яан жянь олон зүйлээр улиран хувилах эрдэмтэйгээр дүрслэгдсэн юм. Жишээлбэл, тус үлгэрийн хоёрдугаар дэвтэрт: “Юнь шяо (云霄 yún xiāo) өгүүлрүүн: “чи хэрхсэн (яасан) хүн?” Яан жянь хариу өчрүүн: “Би болбоос Юй чюань шань уулын Жинь шя дун (金霞洞 jīn xiá dòng) агуйд суусан Юй дин жэнь рэний шавь Яан жянь мөн.” Юнь шяо өгүүлрүүн: “чамд далан

<sup>3</sup> Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн “Бодь мэргэн хаан” хэмээх үлгэрийг Бямбын Ринчен шинжлэх ухааны галигаар тэмдэглэж 1960 онд хэвлүүлснийг Ү сю хуа, Лю ию жие монгол үсэгт буулгав. Дотоод материал. Тус материалаас эшилсэн зүйлийг хаалтад нүүрийн дугаарыг бичиж тодорхойлно.

хоёр хувилах эрдэм буй хэмээн сонссон бөлгөө. Би энэ өдөр чиний урвах хувилах эрдмийг үүсгэж (гаргаж) энэ жагсаалыг эвдэхийг үзсүгэй...” (1984:442) хэмээн Юнь шяо хийгээд Яан жянийг ярилцуулав. Энэхүү ярилцаагаас Яан жянь бол далан хоёр янзаар улиран хувилдаг гэдгийг мэдэж болно.

Дахивал “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т Сү да жи (苏妲己 sū dá jǐ) нь үнэгэн шулмын дүрээр дүрслэгдэж, хаан эзний бага хатан хийгээд сүүл нь цайсан үнэгэн шулмын дүрийн хооронд үргэлж улиран хувилдаг. Тэрээр Жөү ван (纣王 zhòu wáng)-гийн хамгийн хайртай хатан болж, Жөү ван лугаа төрийг түйдэж түмнийг гасалган, өөрийн үйлдсэн гал зуухаар шарах эрүү, түмэн могойт эл мэтийн харгис эрүүгээр шударга журамт гэгээн мэргэн сайд түшмэдийг хилсээр тамлан хорлов. Сү да жигийн ингэж хийж чадсаны гол шалтгаан нь түүний хувилан улирах эрдэм чадалтай нь нягт холбоотой юм.

Үнэндээ хувилж улирах өгүүлэмж бол монгол хятад аман ба бичгийн зохиолд үргэлж илэрдэг чухал нэгэн өгүүлэмж болох юм. Онцгойлон “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”, “Баруунш зорчсон тэмдэглэл” зэрэг шидэт романд хувилж улирах өгүүлэмж үргэлж гардаг. Гэвч Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт гарсан хувилж улирах өгүүлэмж нь “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т гарсан Яан жянь хийгээд Сү да жийгийн хувилж улирахтай зохих харьцаа холбоотой гэж бид үзэж байна. Даруй “Бодь мэргэн хаан”-ы үлгэр дэх тэнгэрийн охин Цагаангалуугийн хувилах өгүүлэмж ба Хожгорхүүхэний улирч хувилах өгүүлэмж нь “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх Яан жянийн хувилах өгүүлэмж ба Сү да жийгийн улиран хувилахтай зохих харьцаа холбоотой болох юм. Хуурч Лувсан Яан жянь хийгээд Сү да жийгийн улирч хувилах өгүүлэмжээс улбаалж, улирч хувилах эрдэм чадалтай тэнгэрийн Цагаангалуу ба Хожгорхүүхэний дүрийг шинээр зохион бүтээсэн болов уу гэж санагдуулж баймуй.

### Хоёр. Дайснаа хад чулуугаар дарах өгүүлэмж

Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хаан эзний хөвгүүн Ширмэнмөндөр аян зам хөөгөөд унтаж амарч байх хооронд, Хожгорхүүхэн ирж түүнийг хад чулуугаар дарж сөнөөх өгүүлэмж гардаг. Түүнд: “зүүн зүгээс Хожгорбэрээлийн / Хожгорхүүхэн/ Үдэншулам, хүүгийн дэргэд хүрч ирээд, хамаг байдаг хуяг дуулга бүгдийг нь хурааж аваад сэлмээ хүүгийн дээрээс далайж, одоо цавчих дээр хүрчээ. Хожгор, доороо хэлжээ: “эх эцэг болоод энэ биеийг чинь хүй тэмтрэх цаг нь одоо болсон юм санжээ. Тэнгэрт ил алахгүй би чамайг, далд ална!” Хожгор, ийш тийшээ харж үзсэн билээ. Баруун талд нь мэлээн (нэлээн) их бүдүүн чулуу байна. Түүнийг өргөж авчраад, хүүгийн дээр хаячихжээ. Хожгор цааш яваад өгчээ. Дарагдашгүй дайснаа нэгэн бүлэг дарлаа, одоо хойш эргэж буцаж, төрийг чинь мөхнө дөө!” (Р63) гэж дүрсэлсэн байна. Энд хоёрдугаар хатны аягач Хожгорхүүхэн, Ширмэнмөндөрийг цус гаргахгүйгээр алах гэж хад чулуугаар дарж тавьсан байна. Энэ мэтээр дайсан этгээдээ хад чулуугаар дарж тавих өгүүлэмж монгол туульд үргэлж гардаг.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т мөн дайснаа хад чулуугаар дарах өгүүлэмж гардаг. Жишээлбэл: “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн дөрөвдүгээр дэвтэрт “Тянь зүнь (天尊 tiān zūn) өгүүлрүүн: “тэр урьд амласан үг бий бөлгөө” хэмээгээд хүчит эр Хуан жинь ли ши (黄巾力士 huáng jīn lì shì)-ийг дуудаж өгүүлрүүн: “чи миний чандмань эрдэнийг аваачиж түүнийг бариад бодь гөрөөст эрэгд дарж миний шийтгэхийг хүлээгтүн” хэмээгээд чандмань эрдэнийг өгсөн хойно Хуан жинь ли ши нэхэж эчээд (очоод) өндөр дуугаар дуудан өгүүлрүүн: “Шэнь гүн бао (申公豹 shēn gōng bào) битгий буруул (зугтаа), Би Тяньн Зүнь-ийн зарлигийг хүлээж, чамайг баривчлахаар ирэв” хэмээгээд чандмань эрдэнийг дээш орхиж Шэнь гүн бао-ыг бариад бодь гөрөөсөн хадны доор дарж тавив.” (СӨҮ, 1984:152) гэсэн байна. Үүнээс өмнө нь Шэнь гүн бао-ыг Юань ши тянь зүнь (元始天尊 yuán shǐ tiān zūn)-

ийн захиагаар Жюй лю сүнх (惧留孙 jù liú sūn) баривчлаад билигт гөрөөст хадны доор дарж тавьсан учир байдаг. Түүнд Шэнь гүн бао-гаар Юань ши тянь зүнх-д үг амалдаж (ам алдаж), амиа мултарсан юм. Тус үлгэрт бас “тайш дотроо санаруун: “таван махбодын увдисаар энэ хүнийг хоривоос болохгүй” хэмээн бодож, алтан ташуураар замын хажуугийн уулыг гурвантаа цохисноо Хуан жинь ли ши хувилгаанаар цаазыг хүлээж, уулын чулууг яаран хийсгэж, Шинь хуань (辛环 xīn huán)-ы арыг цохин унагааж, чулуугаар дарав”<sup>4</sup> гэж Вэнь тайш (闻太师 wén tài shī)-ийн Шинь хуань-ыг чулуугаар дарсан учрыг өгүүлэн тоочжээ.

Дээр тоочсон мэтээр хад чулуугаар дайснаа дарж тавих өгүүлэмж “Бодь мэргэн хаан” ба “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т бүр илэрсэн боловч зарим талаар адил бус. Нэгт, “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт дайсан этгээд нь зөв талын баатрыг хад чулуугаар дарсан байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т зөв талын баатар нь буруу талын баатраа хад чулуугаар дарсан байна. Хоёрт, “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт Хожгорхүүхнээр Ширмэнмөндөрийг алах гэж чулуугаар дарсан байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т дайсан этгээдээ түр цаг хадгалан тавихын төлөө чулуугаар даржээ. Гуравт, “Бодь мэргэн хаан”-ы үлгэр дэх хад чулуугаар дарах өгүүлэмж нь монгол баатрын туулийн уламжлалаас ирэлтээ нь тодорхой, гэвч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх чулуугаар дарах өгүүлэмжтэй ямар ч холбоо харьцаагүй гэж хэлж чадахгүй, харин хоёултай нь бүр холбоо харьцаатай юм.

### Гурав. Үхсэн баатраа дахин амилуулах өгүүлэмж

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хаан эзний их хатан боож үхсэнд охин Цагаангалуу ирж эдгээж авах өгүүлэмж гардаг. Түүнд: “эхийнхээ боож үхсэн модны орой дээр ирж суугаад... цагаан далбаагаараа орой руу нь алгаджээ:

“Асари (гэгээн) нарны чинь гэрэл энд байна.  
Алаг хоёр сайхан үр чинь энд байна.  
Ачит сайхан бэр хүүхэн чинь энд байна.  
Төрийг чинь тэтгэх түмэн тэнгэрүүд энд байна!  
Үхэх цаг чинь болоогүй.  
Хүүрийн биеэсээ битгий ай.  
Энэ хөрст дэлхийд битгий гомд!

Арван зүгийн бодисадва нар буцалтгүйгээр эргэж байна... тэнгэрийн рашаан аманд нь цутгаж өгчээ... гурван мянган ертөнцийг ариутгасан гурвалжин өндгөө би чамд тушааж өглөө шүү. Чи од бос! Хэлэхдээ зэрэг хааны хатан, хамаг бие нь амарч, хамар дээр нь хөлрөөд, хөл бие нь дулаацаад, гэнэт нүдээ нээгээд харсан билээ, олон хүүхэд тойрчихсон байна” (P52) гэж тоочсон юм. Энд охин Цагаангалуугийн хаан эзний их хатныг аврахын төлөө цагаан далбаа сажин залбиран гуйсан гуйлт, хатны аманд тэнгэрийн рашааныг хийж өгсөн үйл явдал, их хатныг “бос” хэмээн дуудсан үйл хэрэг ба их хатны дахин амилсан учрыг нэг нэгээр тоочин өгүүлэв.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т мөн үхсэн хүн дахин амилах өгүүлэмж нэлээд олон удаа гардаг. Жишээлбэл, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн зохиогч бээр: “Үзээсэй Зы я (子牙 zǐ yá), баруун чи газар долоон удаа үхэж гурван зэрэг зовлон тохиолдох тоо буй, тийнхүү өдгөө төв хэмээн дөрвөн хувилгааныг учирч тэргүүн удаа бие эндэх барилдлага болжухуй” (СӨҮ, 1984:232) гэж Жян зы я (姜子牙 jiāng zǐ yá)-ийн үхэх тоо буюу эдгэх тоо жич зовлонд учрах тоог урьдаар уншигчдад тушаасан байна. Тэгээд Жян зы я нэгдүгээр удаа үхсэний дараа түүнийг дахин амилуулсныг: “... Гуан фа тянь зүнх (广法天尊 guǎng fǎ tiān zūn) багшаар эрдэнийг хороон авсны хойно Кун лунь шань уулын зүг мөргөн өгүүлрүүн:

<sup>4</sup> “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” ( хоёрдугаар дэвтэр ), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1984 он, 290-р нүүр.



“шавь би энэ өдөр алах цээрлэлийг нээв” хэмээгээд Жинь жа (金吒 jīn zhā)-г дуудаж, Зы я-ийн хүүрийг үүрүүлж ууландаа гараад ариун усанд хувилгаан үрлийг зуурч Зы ягийн амны дотор цутгахад Зы я даруй эдгэв” (СӨҮ, 1984:385-387) гэж дүрслэв. Жян зы я-ийн гуравдугаар удаа үхээд эдгэсэн учрыг: “Жао гүн мин (赵公明 zhào gōng míng) барьсан ташуураа дээш орхин илгээхэд, хувилгаан гэрэл гарах нь цахилгаан мэт аюултай. Зы я зайлан завдсангүй ташуурт оногдон гөрөөснөөс унавай... жич өгүүлэх нь Зы я Жао гүн минд цохигдон үхсэн тул түүний ясыг Цэнсян-ий ордонд дамнан оруулав... Гуан чөн зы (广成子 guǎng chéng zǐ) өгүүллүүн: “гайгүй, Зы я-д ийм зовлон тусах тохиол буй” хэмээгээд нэгэн хундага ус авчруулж, нэгэн бөөн эмийг гараар няцлан усанд зуурч, амыг хөшин нээгээд эмийг цутган оруулбай. Нэгэн цаг болсны хойно Зы я өндөр дуунаар “юутай өвдмүй” хэмээн ёолж, нүд нээж үзвээс Ү ван, Гуан чөн зы цөм ширээний өмнө зогсжухуй” (СӨҮ, 1984:232) гэж нарийлаг тэмдэглэв. Тус үлгэрт бас Хуан тянь хуа (黄天化 huáng tiān huā)-ийн үхээд эдгэсэн учрыг: “Жэнь жюнь (真君 zhēn jūn)-ээр агуйгаас гарч үзвээс, Хуан тянь хуа-гийн нүүрний арьс шарлажухуй, нүд аньж огт дуун гарахгүй. Жэнь жюнь-ээр Тун эр (童儿 tóng ér)-ийг дуудан ус авч ир хэмээн авчруулаад хувилгаан эмийг зуураад илдийн үзүүрээр шүдийг нь завсарлуулж, эм цутгаж өгснөө тэр эм даруй хэвлийд ороод, нэгэн цаг болсонгүй, Хуан тянь хуа эдгэж, нүд нээж үзвээс, өөрийн багш хажууд буй” (СӨҮ, 1984:280) гэж тоочсон байдаг.

Дээрх хоёр үлгэр дэх үхсэн баатраа дахин амилуулах өгүүлэмжид адил тал ба адил бус тал бүр байдаг. Адил тал: *Нэгд*, үхсэн баатраа бүр эдгээн авч дахин амилуулав. *Хоёрт*, үхээд эдгэдэг нь бүр зөв талын баатрууд болно, буруу талын баатар байхгүй. Адил бус тал: *нэгт*, “Бодь мэргэн хаан”-ы үлгэр дэх үхсэн хатныг дахин амилуулах өгүүлэмжид сүнс дуудах дуудлагын үг байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх дахин амилуулах өгүүлэмжид сүнс дуудах дуудлагын үг байхгүй. *Хоёрт*, Лувсан хуурчийн хуурдан хэлсэн үлгэрт их хатанд тэнгэрийн рашааныг аманд нь хийж дахин амилуулсан байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т хувилгаан үрэл буюу эмийг аманд нь хийж үхсэн жанжин баатраа дахин амилуулав. *Гуравт*, “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт охин Цагаангалуу: “одоо чи бос!” гэж зарлигдсан байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т иймэрхүү зарлигдах явц байхгүй.

Дээрх ярьсныг хураангуйлбал, Лувсан хуурчийн хуурдан хэлсэн үлгэр дэх үхсэн баатрыг дахин амилуулах өгүүлэмжид бөө мөргөлийн сүнсний ойлголт шингэсэн боловч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т сүнсний ойлголт харагдахгүй. Үүнээс бид Лувсан хуурч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-дэх үхээд эдгэх өгүүлэмжид өөрчлөлт хийж, түүнд монгол соёлын агуулгыг нэмэн оруулж, уул соёлыг улам нэг алхам баялагжуулсан болов уу хэмээн бодож буй.

### Дөрөв. Газрын судлаар явах өгүүлэмж

Газрын судлаар явах өгүүлэмж бол бэнсний үлгэрт олонтоо гардаг өгүүлэмж болно. “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хааны бага хатан аягач Хожгороос ямар ямар эрдэм чадвартай буй гэж асуусанд “газрын судлаар явах нэг эрдэм буй, хөл үгүй далай дээр явж яваад туулах нэг эрдэм буй. Арван зүгийн ад шулмын жагсаалыг гүйцдэг (жагсаах) эрдэм буй” (P15) гэжээ. Хожгорхүүхэн газрын судлаар явах эрдэмдээ түшиглэж, их хатны ордноос хааны ихэр хоёр хөвгүүн Шижиर्मөндөр, Ширмэнмөндөрийг хулгайлан аваачиж далайд хаяв. Тэр бас энэхүү эрдэмдээ түшиглэн Ширмэнбаатар их хатныг алах эсэхийг шалган үзнэ, бас ууланд суусан Шижиर्मөндөр хийгээд Ширмэнмөндөрийн үхсэн эсэхийг шалган үздэг.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т газрын судлаар явах өгүүлэмж олон удаа илэрдэг. Жишээлбэл, ягжгар (бага) биетэй Тү шин сүнх (土行孙 tǔ xíng sūn) газар товчлох увдист нэвтэрч, өдөрт газар доогуур мянган газар (1 газар 500 метр зайг хэлнэ) явж чадна. Түүнтэй адилаар эсрэг талын баатар Жан күй (张奎 zhāng kuí) газар доогуур явахдаа нэн хурдан, өдөрт мянга таван зуун газар явж чадна.

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрт, Ширмэнбаатар хааны зарлигийг гүйцэтгэх хэмээн их хатныг цаазын газар аван явахад Хожгорхүүхэн ч газрын судлаар явж, үнэн худлыг үзэхээр ирнэ. Ширмэнбаатар үүнийг бодож мэдээд газрын судсыг ган төмөр мэт бөглөсөнд, тэр арга бус хоёрдугаар хатны дэргэд буцдаг.

Газрын судлыг бөглөх өгүүлэмж нь газрын судлаар явах өгүүлэмжид багтагдах бага өгүүлэмж болох юм. “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т “Тү шин сүнх хойш хүрээндээ эгж (буцаж) Зы я-д золгон хэлрүүн: “Жан күй газар доогуур явах нь асар бэрх, энэ хүн энд байваас бидэнд ашиггүй болмуй.” хэмээхүйеэ Зы я өгүүлрүүн: “урьд чиний багш чамайг барих цагт увдис үүсгэн газрыг зааж ган төмөр мэт бэх болгосон бөлгөө, өдгөө Жан күйг барья хэмээвээс тэр аргаас бусад аргаар барьж чадахгүй, чи эчиж (очиж) тэр увдисыг сураад, Жан күйг бариваас болмуй уу?” (СӨҮ, 1984:205) гэжээ.

Газрын судлаар явах өгүүлэмж бол голдуу бэнсэн үлгэрт гарч, монгол туульд дэмий илэрдэггүй өгүүлэмж болно. Лувсан хуурч энэхүү өгүүлэмжийг “Бодь мэргэн хаан”-ы үлгэртээ авч хэрэглэсэн нь хятадын шидэт роман “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-тэй шууд холбоотой юм. Лувсан хуурч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийг ихээр товчилж, өөрчлөн зохиож хэлэхдээ түүн дэх чухал нэгэн өгүүлэмж-газрын судлаар явах өгүүлэмж (газрын судлыг ган төмөр мэт бөглөх өгүүлэмжийг багтаана)-ийг залгамжлан авч, Хожгорхүүхний үйл явдалд уусган нийлүүлж, зохион ярьсан өгүүлэмж болов уу хэмээн санаж буй.

### Тав. Зооринд хэвтэн амь гарах өгүүлэмж

Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт зооринд хэвтэн амь гарах сонирхолтой нэгэн өгүүлэмж тэмдэглэгдэн оржээ. Тус үлгэрт, Ширмэнмөндөрийн хадам эх нь түүнийг гэртээ суулгах дургүй тул эхнэр нь түүнийг үүрээд, харанхуй шөнө ууланд гарч, нэг модны ёроолд газар ухаад, биеийнх нь хэмжээгээр тааруулаад, өлөн цагаан өвсийг зулгааж, нөхрийнхөө доор дэвсэж, ам торгоороо нөхрийнхөө биеийг бүрхэж: “Аа, миний нөхөр! Намайг эргээд иртэл амьд л байхыг гуйя даа! Өөр юу хэлэх вэ?” хэмээгээд эхнэр нь нөхрөө хэвтүүлчхээд, эрдэнийн унагыг дэргэд нь уяад, гэдрэг буцсан ба сүүлд нь дахин эргэж ирээд эр нөхрөө аварсан учрыг тоочсон байна. (P68)

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т бас зооринд хэвтэн амь гарах өгүүлэмж гардаг. Түүнд, Зы я хүн алсан ялтан Ү жи (武吉 wǔ jí)-ийн амийг авран гаргахын төлөө авсан аргыг доорх мэт тэмдэглэсэн байна. “Зы я өгүүлрүүн: “чи намайг багш бариваас, би чиний амийг эс гаргаваас болохгүй, чи хэрдээ хурдан эчиж (очиж) ширээний өмнө, чиний биеийн хэмжээгээр дөрвөн тохой зоорь малт. Гэгээ тасармагц зоорины дотор орж хэвт, чиний эхэд өгүүлж тэргүүний дэргэд нэгэн зул, хөлийн дэргэд нэгэн зул шатааж, амууг хоёр атга бие дээрээ орхиул. Биеэ өвсөөр бүтээлгэж шөнө гэгээртэл унтаж босогтун, ингэвээс гайгүй болмуй.” Ү жи багшийн үгийг сонсоод... зоорь ухаж сургасан үгийн ёсоор болов” (СӨҮ, 1984:453-454) “түүнээс Зы я даруй шөнө гуравдугаар жингийн цагт үсийг унагаж, илд барин ган (одын нэр) одыг гишгэж, дэү (одын нэр) одыг дохин хуруу дарж, хумс няслаад тарнийн хүрд бичин Ү жи-ийн учирт одыг дайв (тахих)” (СӨҮ, 1984:454).

Дээр танилцуулсан хоёр өгүүлэмжид адил тал ба адил бус тал бүр байдаг. Адил тал: *Нэгд*, “Бодь мэргэн хаан”-ы үлгэр дэх Ширмэнмөндөр ба “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх Ү жи бүр зооринд хэвтэсний сайнаар амь биеэ хамгаалж үхэх аюулаас зайлж чадсан байна. *Хоёрт*, хоёр үлгэрт ухсан зоорь нь бүр биеийн хэмжээгээр хэмжээлж, нэг хүн хэвтэх гэмээр хэмжээтэй ухсан байна. *Гуравт*, хоёр үлгэрт зооринд орж хэвтээд дээрээ бүр тус тус юм бүрхүүлжээ. Адил бус тал: *Нэгд*, “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт өлөн цагаан өвсийг зулгааж нөхрийнхөө доор дэвсэж өгсөн байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т энэхүү үйл явдал байхгүй. Энд Ширмэнмөндөрийн эхнэр нь эр нөхөртөө гүн зузаан хайр сэтгэлгээтэй байдгийг гаргаж чаджээ. *Хоёрт*, Лувсангийн үлгэрт, эхнэр нь ам торгоор

нөхрийнхөө биеийг бүрхэж өгсөн байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т өвсөөр бүрхэж өгчээ. Энд мөн Ширмэнмөндөрийн эхнэр нь эр нөхөртөө хайр сэтгэлгээтэй байдгийг харуулж чаджээ. *Гуравт*, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т, тэргүүний дэргэд нэгэн зул, хөлийн дэргэд нэгэн зул шатааж, амууг хоёр атга бие дээрээ орхиулсан байхад, Лувсангийн үлгэрт иймэрхүү үйл явдал байхгүй. Энэ нь хятад үндэстний тариалах соёл ба бумбын шашны нөлөөг харуулсан байна. *Дөрөвт*, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т одон дахих учир байхад, Лувсангийн үлгэрт одон дахих учир байхгүй. Гэвч хуурын үлгэрт цэргийн юаньшуай “илд барин ган одыг гишгэж, дэү одыг дохин” цэрэг жагсаах дүрслэл олонтоо гардаг. Энэ нь бумбын шашинтай холбоотой байж, юаньшуай-ийн тэнгэрийн зарлигийг уламжилж байгаа явдал болох юм.

Дээрх хоёр үлгэр дэх үлгэрийн баатар зооринд хэвтэн амь гарах өгүүлэмж нь хэдийгээр зарим нарийн зүйлсийн зураглал нь жаахан адилгүй боловч үндсэн агуулга чиглэл нь адил. Гэтэл монгол тууль хийгээд аман үлгэрт иймэрхүү өгүүлэмж тун цөөн байдаг. Үүнээс хуурч Лувсангийн хэлсэн үлгэр дэх энэхүү өгүүлэмж нь “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх өгүүлэмжээс ирэлттэй болохыг таамаглаж болно. Гэвч Лувсан хуурч зарим нарийн зүйлсэд монгол зан заншлаар жаахан өөрчлөлт оруулжээ.

### Зургаа. Биеэрээ өглөг өгөх өгүүлэмж

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрт, хааны их хатан хөдөө хээр хоёр хүүхдээ эрэн тэнүүчлэн явах зам зуур Богд цагаан өвгөнтэй уулзан биеэрээ өглөг өгөх онцгой нэг зүйлийн өгүүлэмж гардаг. Түүнд: “хатан гайхшаа тасраад, би одоо юугаа өгдөг юм билээ? гэж бодсон сон, Өө! үнэхээр, алагдана гэж явахынхаа цагт амийг минь уучилсан Ширмэнбаатар хүүгийн алтан бугуйвч нь байна л даа. Тэрийгээ мартчихжээ! “Би танд алтан бугуйвчаа бариа!” “Чиний тэр хар тунгаар яадаг юм?” Хатан үүнийг нь дуулаад, гайхшаа барж “Би одоо юугаа өгдөг юм билээ би?” Бодож бодож, гайхаж гайхаж, аа, “Би биеэрээ өглөг өгье!” Ирт чулуу авч, баруун гуяынхаа магнаас гурван лангийн хэмжээтэй авч, тэр өвгөний өөдөөс мөлхөөд очжээ. “Гурван мянган ертөнцийн амьтан бүгдийн амарлингуй байхыг өршөө!” Өвгөн тэр махыг нь аваад, юу гэж их сайхан юм өгөх юм бэ! гэж баярлажээ” (P45) гэж тэмдэглэв. “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т хэдийгээр биеэрээ өглөг өгөх өгүүлэмж гарсангүй боловч түүнтэй нэлээд ойролцоо нэгэн өгүүлэмж гарсныг дурдах чухалтай. Энд Шан улсын Жэу хаанаар Жи чан (姬昌 jī chāng)-ын хөвгүүн Бо и као (伯邑考 bó yì kǎo)-ыг алж махаар нь боорцог хийж аавд нь идүүлсэн үйл явдлыг тоочжээ. Түүнд Жи чан-аар боорцог идсэн байдлыг: “Жи чан ширээний өмнө сөгдөөд боорцог хийсэн тэвшийг нээн өгүүллүүн: “Богд эзэн морин дээр зовж яваад олсон бугын махны боорцгийг ялтай түшмэлд шагнан идүүлсэн нь, хаан түмэн нас болтугай” хэмээн мөргөөд, нэгэн дараагаар гурван боорцгийг авч идээд, тэвшний амсрыг дарав. Ирсэн элчээр Жи чан, түүний хөвгүүний махыг идсэнийг мэдээд дотор сэжиглэж санаруун: “хүн Жи чан-ыг урьд тэнгэрийн сахиулсны тоог олж мэдмүй, муу сайныг ухмуй хэмээсэн бөлгөө, энэ өдөр хөвгүүний махыг идсэнийг үзвээс, тэсгэлгүй аманд амттай мэт, Ин ян (阴阳 yīn yáng)-ийн (арга билиг) ёсыг олоод сайн мууг ухмуй хэмээсэн нь цөм ташаа үг” хэмээн бодов” (СӨҮ, 1984:386-381) гэж тоочсон байна. Түүний дараа нь Жи чан улстаа дутаан (зугтаан) хариад идсэн гурван боорцгоо бөөлжин гаргасан үйл явдлыг ч өгүүлэн тоочсон юм. Биеэрээ өглөг өгөх өгүүлэмж ба хөвгүүнийхээ махыг идэх өгүүлэмж нь хоорондоо зохих харьцаа холбоотой юм. Бурхан шашныг шүтдэг монголчууд “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх хөвгүүнийхээ махыг идэх өгүүлэмжийг хүлээн авахад хүчиртэй (чадахгүй) юм. Лувсан хуурч энэхүү байдалд хандуулж уулын байсан хөвгүүнийхээ махыг иддэг өгүүлэмжийг өөрчлөөд биеэрээ өглөг өгөх өгүүлэмж болгосон байна. Ингэж өөрчилснөөс тэрхүү өгүүлэмж нь бурхан шашны ёс номлолд нийцэх болсон мөртөө, монголчууд ч амархан хүлээн авч чадах болгожээ. Энэ бол Лувсан хуурчийн тус өгүүлэмжид хийсэн чухал нэгэн өөрчлөлт болох юм. Үүнээс Өлзийн Лувсан хуурч бол Хятадын бэнсэн

үлгэрийг уламжлан хэлэхдээ түүн дэх өгүүлэмжийг уул хэвээр нь хэлдэг биш, харин монгол сонсогчдын шашин суртахуун, зан заншил ба дур таашаалд нийцүүлж, шинээр өөрчилж, шинэ өгүүлэмжийг зохион гаргадаг гэдгийг мэдэж болно.

### Долоо. Тэрэг зүтгэж нас олох өгүүлэмж

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрт, хаан эзний их хатан үр хөвгүүнээ эрж зүдэрч яваа үедээ Богд цагаан өвгөнтэй тааралдаж, түүний тэргийг зүтгэсэн байдлын тухай: ““Багш минь, би суух үгүй. Та тэргэн дээрээ суу. Би аралд чинь ороод зүтгэе!” Өвгөн тэргэн дээрээ гараад суужээ. Хатан, арал дунд нь ороод, ачит дээд багш минь гэж нэг зүтгэж, аав ээж минь, арван зүгийн минь бурхан гээд хоёр зүтгэж, үргүй амьтан үрийн хутгийг олох болтугай гээд гурав зүтгэжээ. Дэлхий дахины амьтан урт настай болох болтугай гэж дөрөв зүтгэж, эзэн төрд эргэж төрөхийн түмэн ерөөлийг тавья гэж тав зүтгэв. Хонгор хоёр үртэйгээ уулзахын ерөөлийг тавьж зургаа зүтгэв. Хатан: “Ёох!” гээд гэнэтхэн зогсоод өгчээ. Цаад өвгөн хэлжээ: “най, най! Гагцхан алхам дутуу явсан даа” гэж амаа барьжээ. “Үгүй, багш минь, би одоо зүтгэчихье дээ!” “Гүйцсэн, чиний зүтгэгчийн хэмжээ чинь, гүйцсэн! Хоёр зуун хорин насыг өгье гэсэн юм сан даа, хорин нас хасагдлаа даа!”” (Р46) гэж тоочив.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т тэрэг зүтгэж нас олох өгүүлэмж байдаггүй боловч түүнтэй ойролцоо нэгэн өгүүлэмж байдгийг анхаарахгүй байж эс болно. Түүнд Жэу улсын Ү ван (武王 wǔ wáng) эрдэмтнийг хэрхэн хүндэтгэж байгаа үзэл санаа ил тод харагдаж байгаа юм. Тус үлгэрт: “Зы я хойд гэрт яаран орж даоши (道士 dào shì-хувилгаан) хувцас өмсөж гарахуйяа, Ү ван биеэ мөхийн ёсолж өгүүллүүн: “юаньшуай зүтгүүр тэргэнд давшиж суутугай.” Зы я яаран ёсолж вангийн хамт зэрэгцэж яван их хаалганд хүрсэн хойно Ү ван бие мэхийж, Зы я-ыг өргөж тэргэнд суулгасан хойно Сань и шэн (散宜生 sǎn yí shēng) өгүүллүүн: “их ван тэргийг түлхтүгэй” хэмээхүйд, Ү ван тэрэгний сүүлд эчиж (очиж) гурван алхам түлхэв” (СӨҮ, 1984:318) гэсэн байна. Харин “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн үргэлжилсэн телевиз жүжигт Ү вангаар Жян зы я-ын суусан тэргийг 791 алхам зүтгэснээс Жэу улс 791 жил төр барьсан гэж тоочсон байна”<sup>5</sup>.

Дээрх харьцууллаас бид доорх зүйлийг мэдэж болно. Нэгд, “Бодь мэргэн хаан”-ы үлгэр дэх хааны их хатнаар Богд цагаан өвгөний тэргийг зүтгэсэн өгүүлэмж бол “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ээс ирсэн юм. Түүнд их хатан Богд цагаан өвгөний тэргийг зургаан удаа зүтгэсэн гэж хэлсэн бол, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т Ү вангаар Жян зы я-ын суусан тэргийг гурав удаа зүтгэсэн гэжээ. Энэ нь зүтгэсэн тооны хувьд маш ойролцоо болсон байна. Хоёрт, Лувсан хуурчийн хуурдан хэлсэн үлгэрт их хатан Богд цагаан өвгөний тэргийг зүтгээд 200 жилийн өндөр насыг олсон гэсэн бол, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн нэгэн хувилбарт Ү вангаар Жян зы я-ын суусан тэргийг зүтгээд Жэу улсын төрийн эрхийг 791 жил олсноор тоочсон байна. Гуравт, “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт, их хатнаар Богд цагаан өвгөний суусан тэргийг зүтгэж 200 жилийн урт насыг олсон нь голдуу Богд цагаан өвгөний эрлэгийн элч болохтой холбоотой юм. “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т Ү вангаар Жян зы я-ын суусан тэргийг зүтгээд 791 жилийн Жэу улсын төрийг олсон нь голдуу Ү вангийн эрдэмтэн мэргэдийг хүндлэн үздэгтэй холбоотой юм. Эндээс бид Лувсан хуурч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийг товчлон хэлэхдээ түүн дэх Ү вангийн тэрэг зүтгээд Жэу улс 791 жилийн төрийн эрх олсныг их хатан тэрэг зүтгээд 200 жилийн урт насыг олсноор өөрчилснийг мэдэж болно. Өгүүлэмжийг ингэж өөрчлөх нь “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн бүхий л үлгэр үйл явдалтай нийцсэн мөртөө монгол хүлээн авагчдын дур сонирхолд ч нийцсэн байна.

<sup>5</sup> <https://www.smmmy365.com/a56285.html>



### Найм. Заяа бодох өгүүлэмж

Заяа бодох өгүүлэмж бол монгол хятад уран зохиол, цаашилбал бүх дэлхийн уран зохиолд нийдэм байдаг түгээмэл шинжтэй уран зохиолын өгүүлэмж болох юм. Учир нь заяа бодох өгүүлэмж бол өнгөрсний нийгмийн амьдралд нэлээд түгээмэл оршиж байсан үзэгдэл болно.

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрт, хаан эзний тайз Шижирмөндөр Гантулгат хааны төрд ирж Хожгорхүүхэнийг устгаж заяат нөхрөө олохын төлөө заяа бодож явсан үйл явдлыг тоочсон байна. Түүнд: “өнөө Шижирмөндөр хүү, нэг дэвтэр номыг авч, түмэн ард мянган иргэний заяаг бодож явна би! Хамаг олны хамгийн доор, хааны үүдэн дээр сууж байв. Түм түмэн ардууд хэлэлцэж: “Энэ хүний байдлыг үзвэл, лав лавдуу, бидэн олны заяаг бодмоор хүн харагдана!” Олон ардууд хэлэлцэж: “олноороо заяа заяагаа бодуулья! Хийсэн нүгэл буян, ирэх нүглийг бодуулья!” Арцсан толь лугаа адил, хүү тоолж өгнө. Олсон мөнгө зоосыг өөрийн биед шингээсэнгүй, ядуу хоосонд өгч, хоёр гурван өдрийн өглөгийг олны заяаг бодсоор өнгөрөөд...” (P104) гэж тоочсон байна.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-г ч заяа бодох өгүүлэмж олонтоо гардаг, онцгойлон Жян зы я-ын заяа бодож явсан үйл явдал нь Шижирмөндөрийн заяа бодож заяаны амрагаа олсон үйл явдалтай нэлээд ойролцоо байдаг. Түүнд: “Жян зы я-ын эхнэр Ма ши (马氏 mǎ shì) өгүүллүүн: “тийм болбоос хүний заяа хутгийг бас үзэж чаднам буюу?” Зы я өгүүллүүн: “би маш боловсорчээ. Ганц суух гэргүй тул түүгээр явахгүй амуй” хэмээн хэлэлцэж атал (байтал)... И рэнь өгүүллүүн: “гэрийн төлөө юуны зовох ажээ? Чао гө (朝歌 cháo gē) хотны өмнө хаалга их л хөөр хөгжөөнтэй, тэндэх нэгэн тасалгаа гэрийг засаж, Зы я-г суулгая” хэмээгээд... тэндээс Зы я-ын төлгө үзэх Чао гө хотод маш алдаршиж, цэрэг иргэн цөм таван цянь (цэн) мөнгө өгч төлгө үзүүлмүй” (СӨҮ, 1984:307-314) гэж тоочсон байна. Жян зы я энэ аргаар хаан эзэнд танигдаж, хааны ордонд орж пипа (琵琶 pí pá-нэгэн зүйлийн хөгжмийн зэвсэг)-ийн шулмыг хувилгаан галаар шатаасан юм.

Дээрх хоёр үлгэр дэх заяа бодох өгүүлэмж нь зарим талаар нэлээд адил. Жишээлбэл, заяа бодож явсны зорилго нь бүр адил. Шижирмөндөр хаан эзэнд танигдаж, Хожгорхүүхэнийг устган, хааны гүнжтэй хуримлахын төлөө заяа бодсон байхад, Жян зы я хаан эзэнд танигдаж, хааны ордон дахь пипа-ийн шулмыг устгахын төлөө заяа бодсон байна. Гэвч бас адил бус зүйл ч бий. Жишээлбэл, Шижирмөндөр заяа бодоод олсон мөнгөө бүхнийг ядуу зүдүү ард олонд хуваан өгсөн байхад, Жян зы я заяа бодоод олсон мөнгөө ядуу зүдүү ард түмэнд түгээж өглөө гэж бичсэнгүй. Энэ нь түүний эхнэр Ма ши-ийн зоос мөнгөнд ховдог зан чанартай нь холбоотой байх. Бидний үзэхээр, Лувсан хуурчаар “Бодь мэргэн хаан”-ий үлгэрээ хуурдан хэлэхдээ “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх Жян зы ягийн заяа бодсон өгүүлэмжийг өөрийн хэлж байгаа үлгэр үйл явдалтайгаа зохицуулан жаахан өөрчлөлт оруулж, Шижирмөндөрийн заяа бодсон үйл явдлыг зохион гаргасан байна. Гэвч заяа бодох өгүүлэмж бол дэлхийн олон үндэстэн ястны уран зохиолд түгээмэл байдаг өгүүлэмж болох юм.

### Ес. Нум сумаар байлдах өгүүлэмж

Монгол тууль ба хуурын үлгэр жич бэнсэн үлгэрт нум сумаар байлдах өгүүлэмж олонтоо гардаг боловч хоорондоо бас зохих ялгаа зөрөөтэй байдаг. Түүнд хуурын үлгэр ба бэнсэн үлгэр дэх нум сумаар байлдах байлдааны дүрслэл нь үндсэндээ адилхан боловч монгол тууль ба бэнсэн үлгэр дэх нум сумаар байлдах байлдааны дүрслэл нь ихээхэн зөрөөтэй юм.

Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэр нь хэдийгээр хуурын үлгэрийн төрөлд багтдаг боловч түүнд монгол баатарлаг туулийн элемент гүнзгий шингэсэн юм. Түүн дэх нум сумаар байлдах өгүүлэмж нь бэнсэн үлгэр дэх нум сумаар байлдах өгүүлэмж бус, харин монгол баатарлаг туулийн нум сумаар байлдах өгүүлэмж болох юм. “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт Ширмэнмөндөрийн Бэхтөмөр өвгөнийг нум сумаар харван

алсан тухай: “хүү нь, нум саадгаа тэлж, тэлж тавиад орхисон билээ. Өвгөний улаан гол зүрхийг нь барьж харвасан сум нь яваад, өвгөний зүрхийг оносонгүй, тэр өвгөн баатрын баруун чихийг сэт харваад гарчээ. Нэг удаа харвах үедээ чихийг минь сэт харваж байна. Ахиад харвах бол, лав зүрхийг минь ононо! Ширмэнмөндөр хүү: “За, өвгөн чи, уур хүчин эрдэм байдаг болбоос, одоо би элгээ яраад өгье. Чи намайг харва!” Тэр өвгөн, төмөр гилбэртэй сумыг барьж, үд нарны үед татаад, нар шингэтэл татаж, хүүгийн улаан зүрх рүү тавьсан нь, хүүгийн төмөр дөрөөг тас харвачихжээ. Хүү сумыг нь эргүүлж аваад: “За, өвгөн, би чамайг одоо өөрийн чинь зэмсэг (зэвсэг)-ээр нэг харвана даа!” Хүү, тэр гилбэрийн сумыг нь алд хар нуман дээр татаж барьж, өдий төдий хүртэл зогсож байгаад даватгасан (харвасан) билээ, өвгөний элгэн дундуур очиж, цээжин биеийг нь нэвт цохиж, түүнээс цаашаа гурван үүлийг нэвт харважээ” (P61) хэмээн дүрсэлсэн байна.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т нум сумаар байлдсан тухай: “Чю инь (邱引 qiū yǐn) хоёр жанжны дараагаар автагдсаныг үзээд цөс хэмхрэн морин жолоо эргүүлтэл Хуан тянь шян жад сунгаж жадалсанд түүний зүүн гуя оногдож аяа хэмээн бархиран морь ташуурдан буруултал (зугттал) Хуан тянь шян (黃天祥 huáng tiān xiáng) ард үүрсэн хүчит нумыг авч зэв онилон зүрхэн эхийг заан харвасанд Чю инь-ийн сүвээ оногдож эмээлийн бүүргийг тэврэн хүрээндээ буруулан орсонд Хуан фэй ху (黃飛虎 huáng fēi hǔ) хэнгэрэг дэлдэн дайлсан цэргээ хураав” (СӨҮ, 1984:233) хэмээн дүрсэлсэн байна. Нум сумаар ингэж байлдах өгүүлэмж “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т нэлээд олон гардаг юм, түүнийг нэг нэгээр жишээлэн хэлэхийг зогсъя. Тус хоёр үлгэр дэх нум сумаар байлдсан өгүүлэмжийг адилтгаж үзвэл, адил тал байхын хамт адил бус тал ч оршиж байдаг. Адил тал: тус хоёр үлгэрт, нум сумын хувилгаан хүчинд түшиглэн дайсан этгээд буюу эсрэг этгээдээ ялан дийлсэн байна. Адил бус тал: “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт Лувсан хуурч монгол туулийн уламжлалыг залгамжлан нум сумын ид хүчийг хэт их давуулан хэлсэн байхад, “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т нум сумын ид хүчнийг ахуйч үзлийн зохион бүтээх аргаар бодит байдалд нийцүүлэн зохион ярьсан байна. Эндээс бид, хуурч Лувсангийн хятад бэнсэн үлгэрийг хуурдан хэлэхдээ монгол туулийн зарим өгүүлэмжийг бэнсэн үлгэртээ шууд шилжүүлэн, уусган хэрэглэдэг онцлогийг мэдэж болох юм. Тэр энэхүү аргаар хятадын бэнсэн үлгэрийг улам илүү монгольжуу болгож, монгол сонсогчдын хүлээн авахад амархан болгож байсан байна.

### Арав. Усанд наадах (загас гөхдөн наадах) өгүүлэмж

Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хааны хоёр тайз Шижирмөндөр хийгээд Ширмэнмөндөр хоёул Хожгорхүүхэн лүгээ далайн усанд алтан түмпэнгээр наадаж байсаар түүнээ Хожгорхүүхэнд алдах өгүүлэмж гардаг. Энэ нь “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх Жян зы я-ийн голын уснаас өгөөшгүй гөхөөр загас гөхөдсөн өгүүлэмж лугаа холбоотой шиг санагдаж баймуй. “Бодь мэргэн хаан”-ы үлгэрт хааны хоёр тайз Шижирмөндөр хийгээд Ширмэнмөндөр хоёул, Хожгорхүүхэн лүгээ далайн усанд алтан түмпэнгээр наадсан тухай: “Одоо биднүүд малиан (нэлээн) тоглолоо. Одоо өмнө янзаар тоглоё. Миний энэ түмпэн бол алт юм, таных ч алт юм. Тэгэхлээр, энэ түмпэнээ хөвүүлэе. Сайн нь хөвдөг юм, муу нь доошоо ордог юм! Хожгор, түмпэнээ усанд тавьсан хөвөөд байжээ. Хоёр хүүхэд, түмпэнээ тавиад оруулсан билээ, усан дотор алга болчихжээ. Ах дүү хоёул уйлалдмуй. Хожгорхүүхэн хэлжээ: Та хоёр маргааш энэ газар хүрээд ир. Би нэг гаргаад өгч үзье. Хоёр хүүхэд, за! гээд буцжээ. Хожгор, юу ч болсон, нэгэн удаа би таныг чадаа байна! Гэдрэгээ буцаад, эх дээрээ хүрээд иржээ. За, хоёр хүүхэд минь, эрдэнийн түмпэнээ яачхаад ирэв? Аа, бид хөгтэй нэг тоглосоор байгаад, усан дээр сайн нь хөвөөд, муу нь орчихдог юм гэнэ. Бид хоёрынх муу юм байжээ, усанд орчихжээ! Хатан их гайхан шагширч: хайран түмпэн! Энэ ууланд одоо бүтэн элгээрээ суухын арга үгүй боллоо!” (P53) гэж дүрсэлсэн байна.

“Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-т Жян зы я-аар өгөөшгүй хоосон гөхөөр загас гөхдөж, “дуртайг нь гөхөндөө оруулж” чаддаг. Тэрээр шороо далдалж гачигдсан иргэдэд туслан, Пань ши (盘溪 pán xī) газар нуугдаж, Вэй шүй (渭水河 wèi shuǐ) голд загас гөхдөн, жаргал зовлонгоо хувь заяанд найдаж, хүний ертөнцийн сайн муу хүйтэн халууныг үл таньснаар хэдэнтээ худалдаа эрхэлсэн ч эс бүтэж, эхнэрээсээ салжухуй. Тэр хэдийгээр дүр төрх хөгшин ч бичиг зэвсгийн эрдэм хосолж, цэргийн эрдэм болон бумбын увдист нэвтрэн, төрөлх зан номхон шударга, төлгө үзэж загас гөхдөх дуртай. Шан улсын Юаньшуай юань хун (元帅袁洪 yuán shuài yuán hóng) Жян зы я-ыг шүүмжлэхдээ түүний загас гөхдөх дур бахад нийцүүлэн: “Жян шан (姜尚 jiāng shàng) чи Пань ши голд суун загас гөхөдсөн хүн тул ганц усны гүн гүехнийг мэдэх бүлгээ. Чамд ямар эрдэм баймуй? Таван боомтод нэг ч эрдэмтэй жанжингүй тул чи завшаанд олж энд хүрч ирсэн буй за, ямар аймшиггүй уран үгээр миний олныг хувьсгамуй” (СӨҮ, 1984:431) хэмээн хэлсэн байна.

Дээрх сийрүүлээс үзэхэд, хоёр тайзын алтан түмпэнгээр далайн усанд наадсан хийгээд Жян зы я-ийн Пань ши голд өгөөшгүй гөхөөр загас гөхөдсөн нь бүр устай холбоотой ажээ. Эндээс бид Лувсан хуурч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх Жян зы я-ийн загас гөхөдсөн өгүүлэмжийг хоёр тайзын алтан түмпэнийг далайн усанд хийж наадсан өгүүлэмж болгон өөрчилсөн болов уу хэмээн таамаглаж буй. Учир нь алтан түмпэн усанд тунан орох ёс учрыг хүн бүхэн бүр мэддэг атал, өгөөшгүй гөхөөр загас гөхдөх гэдгийг ойлгоход хүчиртэй. Тиймээс Лувсан хуурч хүн бүхний ойлгоход амархан өгүүлэмжээр ойлгоход хүчиртэй өгүүлэмжийг орлуулан хэлжээ.

Лувсан хуурчийн үлгэрт Шижирмөндөр ба Ширмэнмөндөрийн хоёр тийш салж явсны учир шалтгааныг алтан түмпэнээ алдсантай холбон ярьсан нь ойлгомж муутай. Хуурч ч гэсэн түүний учир шалтгааныг тодорхойлон ярьсангүй. Гэтэл, Жян зы я-ийн өгөөшгүй гөхөөр загас гөхөдсөн нь өөрийгөө Жөү ванд (纣王 zhòu wáng) танигдуулахын төлөө хийсэн ажиллагаа болох юм. Энд хуурч бээр уул үлгэрийн утга санааг гүнзгий ойлгосонгүйгээс уул үлгэрийн өгүүлэмжийг ингэж өөрчлөн ярьсан магад.

### Товч дүгнэлт

Нэгд, Өлзийн Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн зарим гол өгүүлэмжүүд нь Мин улсын зохиолч Шюй жун линь (许仲琳 Xǔ zhòng lín)-ийн зохиосон “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”<sup>6</sup>-ийн өгүүлэмжүүдтэй нягт холбоотой. Лувсан хуурч бага насандаа өвөг эцэг нараасаа монголчуудын дунд уламжлагдаж байсан “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийг сурч, хуурч болсныхоо дараа, түүнийг Монгол улсад шинээр зохиомжлон, хуурын үлгэр хийгээд монгол туулийн уламжлалаар дахин хуурдан хэлснээс тус хоёр үлгэрийн зарим өгүүлэмжүүд нь нэлээд олон талаар адил болсон байна.

Хоёрт, хоёр үлгэрийн өгүүлэмжийн харьцууллаас Лувсан хуурчийн хуурдан хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэр бол Мин улсын шидэт роман “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ээс эхтэй гэдгийг таамаглаж болох боловч Лувсан хуурч тус үлгэрийг “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн уул янзаар нь, өчүүхэн ч хувиргалгүй хэлсэн бус, харин үлгэр үйл явдлын өгүүлэмжийг өөрчлөх газар нь өөрчлөн, солих газар нь сольсны хамт хуучин өгүүлэмжийн суурин дээр шинэ өгүүлэмжийг зохион, шинэ нэгэн үлгэр болгон зохион хэлсэн юм. Тиймээс хоёр үлгэрийн өгүүлэмж нь их төлөвтөө адил боловч адил бус газар ч нэлээд олон гарсан байна.

Гуравт, хоёр үлгэрийн зарим өгүүлэмжүүд нь зарим талаар жаахан адил бус болсны шалтгаан нь хуурч Лувсан “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн өгүүлэмжүүдийг монголын сонсогчдын дур сонирхолд нийцүүлж, монгол туульд уулаас байсан уламжлалт өгүүлэмжийг тус үлгэрт шилжүүлэн хэрэглэж, шинээр зохиомжлон бүтээсэнд оршино. Үүнд,

<sup>6</sup> Шюй жун линь (1560-1630 он) -ыг “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн зохиогч хэмээн хэлдэг боловч тус романы зохиогч нь хэн болох тухай маргаантай байсаар.

монголчуудын бөө мөргөлийн нөлөө, бурхан шашны нөлөө ба монгол зан заншлын нөлөө чухал үйлдэл үзүүлсэн юм.

*Дөрөвт*, Лувсан хуурч “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ийн зарим өгүүлэмжийн утга санааг сайн ойлгож чадсангүйгээс уул өгүүлэмжийг өөрчлөн хэлсэн зүйл ч байдаг. Гэвч түүний энэхүү өөрчлөлт нь зүй ёсонд эс нийцэж, хүлээн авагчдад төөрөгдөл буюу эндүү төрөгдлийг өгсөн зүйл ч гарсан байна. Хуурч нар үүнээс сэнхрүүлэл авч өөрийн мэдлэг чадвараа үргэлжлэн дээшлүүлэх чухалтай гэдгээ ухаарах хэрэгтэй.

### Abstract

The paper conducts a comparative study to the *Bodi Mergen Khan* chanted by Khuurchi Lobsang and the Classical Novel *Saqiyuluysan Ergümjilegsen Üliger* (the Legend of Deification), and concludes that: first, *Bodi Mergen Khan* by Khuurchi Lobsang was originated from *Saqiyuluysan Ergümjilegsen Üliger*; second, in the *Bodi Mergen Khan* Khuurchi Lobsang, some of the motifs of *Bodi Mergen Khan* were changed, some were replaced, and some new motifs were added; third, Khuurchi Lobsang adapted the story, catering to the audience, with shamanistic, Buddhist and also Mongolian cultural contents.

### Номзүй

- Ринчиндорж.** 2013. *Монгол улсын алдарт хуурч Өлзийн Лувсангийн товч намтар*. Дотоод материал. Анхдугаар удааны хуурын үлгэрийн формын өгүүллийн түүвэр. Өвөр Монголын Үндэстний Их Сургууль.
- Нарангэрэл.** 2003. *Лувсан хуурчид холбогдох түүхийн баримт материалаар сэдэвлэх нь хуурын үлгэрийн өвийг цуглуулах ба судлах асуудалд тавих санал*. Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.
- Дулаан.** 2017. *Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн бодь мэргэн хаан хэмээх үлгэрийн тухай судлал*. Уламжлал ба харьцуулал утга зохиол судлалын хэлхээгүй сувд, Дээд дэвтэр. Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Монгол туулийн товч толь.* 2013. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Нүүдэл соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн. Улаанбаатар.
- Ү сю Хуа, Лю юй же** монгол үсэгт буулгав. 2016. Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн Бодь мэргэн хаан хэмээх үлгэрийг Бямбын Ринчен шинжлэх ухааны галигаар тэмдэглэж, 1960 онд хэвлүүлснийг, Ү сю Хуа, Лю юй же монгол үсэгт буулгав. Дотоод материал. *Сахиулсан өргөмжилсөн үлгэр* (1-4 дүгэр дэвтэр). 1984. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.
- 许仲琳: “封神演义” (上下册), 广东人民出版社, 1980年。  
<https://www.smmmy365.com/a56285.html>